



Улаанбаатар хот, СХД, 15 –р хороо, 20-314,  
Утас: 91917137 www.info@nots.mn  
<http://www.nots.mn>

2022.11.04 № 22/024  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

“НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ  
ОРЧНЫ ГАЗАР”-Т

Г Хүсэлт гаргах тухай Г

“НОЦ БЕТОН ЗУУРМАГ” ХХК /РД:5809665/ нь Улаанбаатар хотын ХАН-УУЛ дүүргийн 3-р хороонд байрлаж бетон зуурмаг үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Манай компанийн зүгээс 2020 онд Бетон зуурмагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг газартаа Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн.

Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсаны дагуу 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг батлуулах хүсэлтэй байна.

Жич: 2022 онд хийгдсэн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хавсралтаар хүргүүлж байна.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:



/Ч.АРИУНЗАЯА/

**“НОЦ БЕТОН ЗУУРМАГ” ХХК**

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ОРШИХ БЕТОН ЗУУРМАГИЙН  
ҮЙЛДВЭРИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**



**УЛААНБААТАР ХОТ**

**2022 ОН**

---

“НОЦ БЕТОН ЗУУРМАГ” ХХК

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 3-Р ХОРООНЫ НУТАГТ ОРШИХ БЕТОН  
ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭРИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ  
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТЕРИЙН ДУГААР:5809665/

**ХЯНАСАН:**

НБОГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

/Ж.БАТЗОЛБОО/

**БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:** УЛААНБААТАР ХОТ

“НОЦ БЕТОН ЗУУРМАГ” ХХК-ИЙН

МЕНЕЖЕР



/Б.ЭРДЭНЭЗУЛ/

**УЛААНБАТАР ХОТ  
2022 ОН**

**АГУУЛГА**

ОРШИЛ.....	1
НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	2
1.1 Төслийн нэр.....	2
1.2 Төслийн зорилго.....	2
1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн нэр хаяг.....	2
1.4 Төслийн байршил.....	2
1.5 Төслийн төлөвлөлт, хүчин чадал .....	3
1.6 Үйлдвэрийн технологи, түүхий эд, материалын хэрэглээ.....	5
1.6.1 Үйлдвэрийн технологи.....	6
1.6.2 Үндсэн ба туслах түүхий эд материалын хэрэглээ.....	6
1.6.3 Ус хангамж хэрэглээ.....	7
1.6.4 Цахилгаан эрчим хүч, дулаан хангамж.....	8
1.7 Эцсийн бүтээгдэхүүн.....	8
1.8 Хог хаягдал.....	11
ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	12
ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	14
ДӨРӨВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	16
ТАВ. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	17
ЗУРГАА. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	18
6.1 Хог хаягдлыг эрх бүхий байгууллагаар тээвэрлүүлдэг байдал.....	18
6.2 Шингэн хаягдлыг бохирын цооногийн дүүрэлтийг 80 хувиас хэтрүүлэхгүй соруулан зайлуулдаг байдал.....	19
ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	21
НАЙМ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	22
ДҮНГЭЛТ.....	23

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаа явуулж буй талбайн эргэлтийн цэгүүдийн солбилцол.....	4-5
Хүснэгт 2. Бетон зуурмагийн үйлдвэрийн түүхий эд, туслах материалын жилийн хэрэглээ.....	8
Хүснэгт 3. Үйлдвэрийн технологи болон унд ахуйн ус хэрэглээ (Ус хэрэглээний нормоор).....	10
Хүснэгт 4. Болзошгүй нөлөөллийн жагсаалт.....	14-16

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Үйлдвэрийн байршил.....	5
Зураг 2. Бетон зуурмагийн үйлдвэрийн суурин тоног төхөөрөмж.....	6
Зураг 3. Бетон зуурмагийн үйлдвэрийн орчны газар ашиглалтын өнөөгийн байдал.....	7
Зураг 4. Бетон зуурмагийн үйлдвэрийн технологийн схем.....	8
Зураг 5. Түүхий эд (элс, хайрга, дайрга)-ийн талбай.....	9
Зураг 6. Үйлдвэрийн усны нөөцийн танкнууд.....	9
Зураг 7. Нэмэлт бодис хадгалах сав.....	9
Зураг 8. Дамжуулах бункер, туузан дамжуулагч.....	9
Зураг 9. Бетон зуурмагийн үйлдвэрийн талбайд байрлах гүний худаг.....	10
Зураг 10. Бэлэн болсон бетон зуурмагийг зориулалтын холигч тээврийн хэрэгсэлд юүлж буй байдал.....	11
Зураг 11. Бетоныг барилгын талбайд буулгаж буй байдал.....	11
Зураг 12. Үйлдвэрийн чанарын хяналтын лаборатори.....	13
Зураг 13. Ахуйн хатуу хаягдлын цэг.....	13
Зураг 14. Ажилчдын бие засах газар, ариун цэврийн өөрөө, бохирын цооног.....	14
Зураг 15. Тунгаагуурын сан.....	14
Зураг 16. Үйлдвэрийн хашаан доторх шороон замыг дагтаршуулсан байдал.....	17
Зураг 17. Машин механизмуудыг техникийн үзлэг оношилгоонд хамруулсан байдал.....	17
Зураг 18. Намар мод тарьсан байдал.....	18
Зураг 19. Хавар мод тарьсан байдал.....	19
Зураг 20. Осол аваар гарч болзошгүй хэсгүүдэд байршуулах.....	20
Зураг 21. Анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг байнга бэлэн байлгах.....	20
Зураг 22. Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг хангаж, галын хорыг цэнэглэх.....	20
Зураг 23. Ажлын дахь ХАБЭА болон болзошгүй осол аваарын үед анхан шатны тусламж үзүүлэх сургалтыг нийт ажилчдын дунд зохион байгуулсан байдал.....	21
Зураг 24. Үйлдвэрийн орчинд хогын савыг 3-н төрлөөр ялгаж ангилан байршуулсан байдал.....	22
Зураг 25. Усны шинжилгээний дүн.....	24
Зураг 26. Агаарын шинжилгээний дүн.....	25
Зураг 27. Хөрсний шинжилгээний дүн.....	25

### ОРШИЛ

"Ноц Бетон Зуурмаг" ХХК нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хороонд байрлах Бетон зуурмагийн үйлдвэртээ 2020 онд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг байгаль орчны үнэлгээ, зөвлөх үйлчилгээний "Нью Грийн Ворлд" ХХК-аар хийлгэж, БОАЖЯ-аар батлуулсан бөгөөд улмаар 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.

Тус 2022 оны БОМТ-нд тусгагдсан байгаль орчныг хамгаалах болон хяналт шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэн энэхүү биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын 4.1-т заасны дагуу Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын дагуу "Ноц Бетон Зуурмаг" ХХК боловсрууллаа.

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн нэр

Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ-2022)

### 1.2. Төслийн зорилго

Энэхүү бетон зуурмагийн үйлдвэр нь чанарын шаардлага хангасан түүхий эд материалаар сүүлийн үеийн дэвшилтэт, бүрэн автомат техник тоног төхөөрөмжийг ашиглан олон улсын стандартад нийцсэн дээд зэргийн чанартай бетон зуурмагийг үйлдвэрлэж дотоодын зах зээлд нийлүүлэх, улмаар улсын төсөвт төлөх татварын орлогыг нэмэгдүүлэх, шинээр ажлын байр бий болгох, барилгын салбарыг хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулах зорилготой үйл ажиллагаа явуулдаг.

### 1.3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр хаяг

"Ноц бетон зуурмаг" ХХК  
Улсын бүртгэлийн дугаар: 9011442083  
Регистрийн дугаар: 5809665  
Хаяг: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг,  
15-р хороо, Өнөр хороолол 20, 314 тоот  
Утас: 91917137


### 1.4. Төслийн байршил

"Ноц бетон зуурмаг" ХХК-ийн "Бетон зуурмагийн үйлдвэр" нь Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт, ТЭЦ-3-ын баруун талд, үйлдвэрлэлийн бүсэд байрлах "Эн Өү Ти Эс" ХХК-ийн эзэмшил нийт 7699 м<sup>2</sup> талбайг түрээслэн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байна. Түрээслэн ашиглаж буй газрын эргэлтийн цэгүүдийн координатыг хүснэгт 2-1-ээр, үйлдвэрийн байршлыг зураг 2-1-т тус тус харуулав.

Хүснэгт 1. Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагаа явуулж буй талбайн эргэлтийн цэгүүдийн солбицол

Цэгийн дугаар	Өргөрөг	Уртраг	Цэгийн Дугаар	Өргөрөг	Уртраг
Нэгж талбарын дугаар -1780912065, Газрын хэмжээ 4200 м <sup>2</sup>					
1	47°53'43.28"N	106°51'18.06"E	9	47°53'45.01"N	106°51'21.29"E
2	47°53'44.20"N	106°51'17.89"E	10	47°53'45.13"N	106°51'22.49"E
3	47°53'44.26"N	106°51'18.49"E	11	47°53'44.28"N	106°51'22.76"E
4	47°53'45.11"N	106°51'18.34"E	12	47°53'44.15"N	106°51'21.49"E
5	47°53'45.25"N	106°51'19.57"E	13	47°53'43.67"N	106°51'21.60"E
6	47°53'45.39"N	106°51'20.79"E	14	47°53'43.53"N	106°51'20.41"E
7	47°53'44.52"N	106°51'20.99"E	15	47°53'43.40"N	106°51'19.24"E
8	47°53'44.57"N	106°51'21.39"E			
Нэгж талбарын дугаар -1780912214, Газрын хэмжээ 3499 м <sup>2</sup>					
1	47°53'45.13"N	106°51'22.49"E	10	47°53'46.88"N	106°51'22.10"E
2	47°53'45.01"N	106°51'21.29"E	11	47°53'47.12"N	106°51'23.53"E

3	47°53'45.43"N	106°51'21.20"E	12	47°53'46.42"N	106°51'23.76"E
4	47°53'45.91"N	106°51'21.08"E	13	47°53'46.12"N	106°51'22.41"E
5	47°53'45.74"N	106°51'20.00"E	14	47°53'46.10"N	106°51'22.32"E
6	47°53'45.53"N	106°51'18.68"E	15	47°53'46.01"N	106°51'22.35"E
7	47°53'46.32"N	106°51'18.55"E	16	47°53'45.98"N	106°51'22.16"E
8	47°53'46.98"N	106°51'21.42"E	17	47°53'45.56"N	106°51'22.31"E
9	47°53'46.79"N	106°51'21.53"E	18	47°53'45.56"N	106°51'22.33"E



Зураг 16. Үйлдвэрийн байршил


### 1.5. Төслийн төлөвлөлт, хүчин чадал

"Бетон зуурмагийн үйлдвэр" нь 2014 оны 08 сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд М100-М500 маркийн бетон зуурмагийг үйлдвэрлэн дотоодын хэрэглэгчдэд нийлүүлж байна.

Энэхүү үйлдвэр нь БНХАУ-ын "ZOOMLION" фирмийн бетон зуурмагийн бүрэн автомат суурин тоног төхөөрөмжөөр тоноглогдсон. Уг тоног төхөөрөмж нь хүчин чадал сайтай, зуурах эд анги, хугацааны тохиргоотой, бүтээгдэхүүнээ гаргах үйлдэлтэй, түүхий эдүүдийн орц найрлагыг цахилгаан жинлүүр, компьютерын программын хяналтан дор хуваарилдаг бүрэн автомат ажиллагаатай юм. Мөн үйлдвэрлэл явуулахад шаардлагатай нэмэлт тоног төхөөрөмж, авто пүү, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг бүрэн хангахуйц цахилгааны дэд станцтай бөгөөд шаардлагатай түүхий эд, материалын нөөцийг харилцагч байгууллагуудаас тасралтгүй нийлүүлж үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тогтвортой явуулдаг.



Жил бүрийн 10-р сарын 20-ноос дараа оны 3-р сарын 20 хүртэлх хугацаанд үйлдвэрийн үйл ажиллагааг бүрэн зогсоож, жилд дунджаар 215 хоног идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Бүрэн хүчин чадлаараа ажиллах үед цагт 120 м<sup>3</sup> бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргах хүчин чадалтай. Одоогийн байдлаар нийт 26 хүнийг ажлын байраар ханган ажиллуулж байгаагаас инженер техникийн ажилтан 6, үйлдвэрийн ажилчин 6, жолооч 14 байна.



*Зураг 17. Бетон зуурмагийн үйлдвэрийн суурин тоног төхөөрөмж*





*Зураг 18. Бетон зуурмагийн үйлдвэрийн орчны газар ашиглалтын өнөөгийн байдал*

## **1.6. Үйлдвэрийн технологи, түүхий эд, материалын хэрэглээ**

### ***1.6.1. Үйлдвэрийн технологи***


Бетон зуурмаг гэдэг нь цемент, ус, элс, хайрга, нэмэлт бодис зэрэг материалуудыг урьдчилан бэлтгэсэн найрлагаар хэмжиж холиод найруулсан бэхжээгүй зуурмагийг хэлнэ.

Бэлэн болсон зуурмагийг тусгай зориулалтын зуурагч машинаар хэрэглэгчдэд хүргэх бөгөөд энэ нь бетон зуурмагийн шингэн чанарыг хадгалж түүхий эдүүдийг холигдсон байдлаар хүргэдэг давуу талтай.

Үйлдвэрлэлийн технологийн үндсэн үйл ажиллагаа нь:

- Түүхий эд материалыг хүлээн авах
- Хадгалах
- Зөөж тээвэрлэх, бэлтгэх
- Зуурмагийг зуурах
- Бэлэн зуурмагийг тээвэрлэн хэрэглэгчдэд хүргэх гэсэн үе шат, дарааллаар явагддаг.

Бетон зуурмагийн үйлдвэрийн технологийн схемийг доорх зурагт үзүүлэв.



Зураг 19. Бетон зуурмагийн үйлдвэрийн технологийн схем

1.6.2. Үндсэн ба туслах түүхий эд материалын хэрэглээ

Үйлдвэрийн үндсэн түүхий эдүүд нь цемент, элс, дайрга (5-10 мм, 10-20 мм), нэмэлт гэсэн материалууд байх ба үйлдвэрийн тээврийн хэрэгсэл, машин механизмуудын ажиллагаанд дизель түлш, тос ашигладаг. Эдгээр түүхий эд материалуудыг дотоодын зах зээлээс харилцагч байгууллагуудтай байгуулсан түүхий эд нийлүүлэх гэрээний дагуу худалдан авч ашигладаг ба жилийн хэрэглээг доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2. Бетон зуурмагийн үйлдвэрийн түүхий эд, туслах материалын жилийн хэрэглээ

д/д	Түүхий эд, материал нийлүүлэгч байгууллагуудын нэр	Материалын нэр, төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	"Батжилт энх" ХХК	Элс	м <sup>3</sup>	13400
2	"Хөтөл Цемент Шохой" ХХК, "Мөнхийн баян гал" ХХК	Цемент	тн	6200
3	"IZKON" ХХК	Нэмэлт бодис (PC-2, PC-3)	тн	68
4	ЦэЦэ импекс ХХК, "Баруун туруун" ХХК	Дайрга (5-10мм, 10-20мм)	м <sup>3</sup>	9787
5	"Магнай Трейд" ХХК	Тос	тн	110
6		Дизель түлш	кг	250-400



Зураг 20. Түүхий эд (элс, хайрга, дайрга)-ийн талбай



Зураг 21. Үйлдвэрийн усны нөөцийн танкнууд

Зураг 22. Нэмэлт бодис хадгалах сав



Зураг 23. Дамжуулах бункер, туузан дамжуулагч

### 1.6.3. Ус хангамж, хэрэглээ

"Бетон зуурмагийн үйлдвэр"-ийн үйл ажиллагааны үед үйлдвэрлэлийн технологи болон ажилчдын унд ахуйн зориулалтаар ус ашиглах ба технологийн ус хэрэглээг үйлдвэрийн талбай дахь 2 л/с-ийн ундаргатай гүний худгаас хангадаг. Үйлдвэрийн үндсэн хүчин чадал нь 120 м<sup>3</sup>/цаг боловч хэрэглэгчийн захиалга болон цаг уурын нөхцөлөөс хамааран хоногт дунджаар 60м<sup>3</sup> бетон зуурмаг үйлдвэрлэдэг. Харин унд ахуйн ус хэрэглээг толгой компани болох "Эн Өү Ти Эс" ХХК-ийн БГД-ийн 4-р хороонд байрлах үйлдвэрийн гүний худгийн уснаас зөвөрөөр хангаж байна.

Бетон зуурмагийн үйлдвэрийн унд ахуй болон технологийн усны хэрэглээг БОНХАЖСайдын А/301 дүгээр тушаалаар батлагдсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм"-ын дагуу

тооцоход хоногт 21.9 м<sup>3</sup>, жилд 4708.5 м<sup>3</sup> ус хэрэглэх тооцоо гарч байна (Хүснэгт 3). Гүний худаг нь хоногт 172.8 м<sup>3</sup> ус гаргах хүчин чадалтай бөгөөд үйлдвэрийн технологийн ус хэрэглээг бүрэн хангах боломжтой.

**Хүснэгт 3. Үйлдвэрийн технологи болон унд ахуйн ус хэрэглээ (Ус хэрэглээний нормоор)**

№	Ус хэрэглээний төрлүүд	Хоногт үйлдвэрлэх бетон зуурмагийн хэмжээ, м <sup>3</sup>	Ажилчдын тоо	Ус хэрэглээний норм (А/301 тушаал)	Хоногийн ус хэрэглээ, м <sup>3</sup>	Жилд ажиллах хоногийн тоо	Жилийн ус хэрэглээ, м <sup>3</sup>
1	Технологи	60	-	0.3 м <sup>3</sup> /м <sup>3</sup> бетон	18.0	215	3870.0
2	Унд, ахуй	-	26	150 л/хоног	3.9	215	838.5
<b>Нийт ус хэрэглээ</b>					<b>21.9</b>	<b>-</b>	<b>4708.5</b>



**Зураг 24. Бетон зуурмагийн үйлдвэрийн талбайд байрлах гүний худаг**

**1.6.4. Цахилгаан эрчим хүч, дулаан хангамж**

Бетон зуурмагийн үйлдвэр нь "УБЦТС" ТӨХК-тай байгуулсан гэрээний дагуу цахилгаан эрчим хүчний төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон. Харин улирлын чанартай ажиллаж, намар үйл ажиллагаагаа зогсоодог тул дулааны шугам сүлжээнд холбогдоогүй болно. Шаардлагатай үед ажилчдын оффисын барилгыг цахилгаан халаагуур ашиглан халаадаг.

**1.7. Эцсийн бүтээгдэхүүн**

Дэлхийн чанарын стандарт болох ISO 9001, байгаль орчинд хор нөлөөгүйг батлах ISO 14001, Монгол усын "Бетон зуурмаг. Техникийн шаардлага MNS 1185:1998" стандартын шаардлага хангасан M100-M500 маркийн бетон зуурмаг үйлдвэрлэн иргэн, үйлдвэр, ХАА, орон сууцны барилга угсралтын талбайд захиалагчийн захиалга, хүсэлтийн дагуу зориулалтын миксер машинуудаар тээвэрлэн хүргэж өгөх бөгөөд жилд дунджаар 10-12 мян м<sup>3</sup> бетон үйлдвэрлэн зах зээлд нийлүүлдэг.



**Зураг 25. Бэлэн болсон бетон зуурмагийг зориулалтын холигч тээврийн хэрэгсэлд юүлж буй байдал**



**Зураг 26. Бетоныг барилгын талбайд буулгаж буй байдал**

Үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүний чанарыг үйлдвэрийн дэргэдэх бүтээгдэхүүний чанарын хяналтын иж бүрэн тоног төхөөрөмж бүхий лабораторид шалгаж, чанар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлдэг бөгөөд 2014 оноос Барилга архитектур корпорацын итгэмжлэгдсэн лабораторитой хамтран ажиллаж чанарын шинжилгээг давхар хийлгэн ажиллаж байна. Энд бетон зуурмагийн гол түүхий эд болох цемент, элс, хайрганы чанар болон зуурмагийн чанарт хяналт тавьж, байнгын туршилт шалгалтыг явуулдаг. Хяналт, туршилтыг "Бетон зуурмагийг турших арга MNS 1170:85", "Барилгын зуурмаг турших арга MNS 2120:99" стандартын дагуу хийж доорх үзүүлэлтүүдийг тодорхойлдог. Үүнд:

Цемент:

- Хэвийн өтгөрөлт
- Барьцалдаж эхлэх, дуусах хугацаа
- 0.08 мм шигшүүр дээрх үлдэгдэл
- Шахалт, гулзайлтын бат бэх (3, 7, 28 хоног)

Элс:

- Чийглэг
- Асгаасан нягт
- Нягт
- Ширхэглэлийн бүрэлдэхүүн

- Тоосорхог хольцын хэмжээ
- Ширхгийн модуль
- Элсэн дээрх хайрганы хэмжээ

Хайрга:

- Чийглэг
- Асгаасан нягт
- Нягт
- Ширхэг хоорондын зай
- Нимгэн үзүүрлэг хэсэг

Бетон зуурмаг:

- Конусын суулт (хөдөлгөөнт чанар)
- Барилгын талбай дээр хийгдэнэ
- Агаарын агууламж (нүх сүвийн хэмжээ)
- Температур

- Ус шингээлт
- Ширхэг хоорондын зай

- Ширхэгийн хэмжээ, бүрэлдэхүүн
- Элэгдэх чанар
- Хайрган дахь элсний хэмжээ
- Тоосорхог хольцын хэмжээ

Бетон:

- Шахалтын бат бэх (3, 7, 28 хоног)



Зураг 27. Үйлдвэрийн чанарын хяналтын лаборатори

### 1.8. Хог хаягдал

Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагааны үед ахуйн хатуу, шингэн хаягдал, бетон зуурмаг тээвэрлэгч "Михег" машиныг угааж цэвэрлэхэд гарах шингэн хаягдал, үйлдвэрийн машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээнээс үүсэх тос тосолгооны материалын хаягдал зэрэг аюултай болон энгийн хаягдлууд үүснэ. Ахуйн хатуу хаягдал хоногт 0.026 тн үүсэх ба үйлдвэрийн хашаан дахь хогийн түр цэгт хуримтлуулж, ХУД-н Тээвэрлэлт үйлчилгээний төв ОНӨААТҮГ-тай байгуулсан "Хог хаягдал ачиж, тээвэрлэх гэрээ"-ний дагуу төвлөрсөн хаягдлын цэг рүү ачуулдаг. Ахуйн шингэн хаягдал хоногт 2.7м<sup>3</sup> орчим үүсэх ба 8 м<sup>3</sup>-ийн багтаамжтай бохирын цооногт хуримтлуулж бохир соруулах машинаар соруулан зайлуулдаг.

Бетон зуурмаг тээвэрлэгч Михег машиныг угааж цэвэрлэхэд гарах технологийн шингэн хаягдлыг 3 дамжлага бүхий тунгаагуурын санд хуримтлуулж эцсийн байдлаар тунаж шүүгдсэн усыг дахин эргэлтийн системээр ашиглахаар төлөвлөн үйлдвэрийн талбайд 8 м өргөн, 10 м урт, 2 м гүнтэй, 160 м<sup>3</sup>-ийн багтаамжтай бетон материал бүхий хаягдлын сан (Зураг 15) байгуулан ашиглаж байна.

Үйлдвэрийн машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээнээс үүсэх ашигласан тосны хаягдлыг "Тэнүүн-Өлзий" ХХК-д нийлүүлдэг. Хариулагчтай батерей, аккумуляторын хаягдлыг Налайх дүүргийн Хятадын хөрөнгө оруулалттай аккумуляторын үйлдвэрт өөрийн унаагаар хүргэж шилжүүлдэг.





Зураг 28. Ахуйн хатуу хаягдлын цэг



Зураг 29. Ажилчдын бие засах газар, ариун цэврийн өөрөө, бохирын цооног



Зураг 30. Тунгаагуурын сан

## ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Бетон зуурмагийн үйлдвэрийн үйл ажиллагааны үед хүрээлэн буй орчны төлөв байдал болон нийгэм, эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, түүний эрчимшил зэргийг магадлан жагсаах аргыг ашиглан тодруулж дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 4. Болзошгүй нөлөөллийн жагсаал

Байгаль орчны үзүүлэлт	Нөлөөллийн хэлбэр		Нөлөөллийн хугацаа		Нөлөөллийн эрчим		
	Шууд	Шууд бус	Богино хугацааны	Урт хугацааны	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт							
Гадаргын урсацын өөрчлөлт	Нөлөөлөл байхгүй						

Газрын доорх усны нөөц	x			x		x
Ургамлын бүтцийн өөрчлөлт		x		x		x
Хөрсний элэгдэл, эвдрэл	x			x		x
Хөрсний үржил шимд нөлөөлөх		x		x		x
Газрын хэвлийн өөрчлөлт				Нөлөөлөл байхгүй		
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт				Нөлөөлөл байхгүй		
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт				Нөлөөлөл байхгүй		
<b>2. Байгалийн нөөц, ашиглалт</b>						
Эрчим хүчний нөөц	x			x		x
Газрын гадаргын нөөц баялаг	x			x		x
Эрдэс түүхий эдийн нөөц				Нөлөөлөл байхгүй		
Бэлчээрийн байдал				Нөлөөлөл байхгүй		
<b>3. Байгаль орчны өөрчлөлт</b>						
Гадаргын усны чанарын өөрчлөлт				Нөлөөлөл байхгүй		
Агаарын бохирдол	x			x		x
Газрын доорх усны чанарын өөрчлөлт		x		x		x
Хөрсний бохирдол	x			x		x
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх				Нөлөөлөл байхгүй		
Дуу чимээ, шуугианы нөлөө	x			x		x
<b>4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор</b>						
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх				Нөлөөлөл байхгүй		
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх				Нөлөөлөл байхгүй		
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх				Нөлөөлөл байхгүй		
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх				Нөлөөлөл байхгүй		
Археологи, палентологийн олдорт нөлөөлөх				Нөлөөлөл байхгүй		
<b>5. Нийгэмд үзүүлэх нөлөө</b>						
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	x			x		x
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх	x			x		x
Хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх		x		x		x
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x		x		x
<b>6. Нийгэм, эдийн засаг</b>						
Орон нутгийн орлого нэмэгдэх		x		x		x
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		x		x		x
Ажлын байр нэмэгдэх	x			x		x
Зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах		x		x		x
<b>7. Болзошгүй аюул осол</b>						
Үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжүүд, машин механизмын бүрэн бүтэн байдал алдагдах, ХАБЭА-н нөхцөл зөрчигдсөнөөс үйлдвэрийн осол аваар гарах		x		x		x
Ажилчдын санамсар болгоомжгүй байдал болон хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээ хэрэглээгүй зэргээс шалтгаалж өндрөөс унаж бэртэх, цохиулах, гар хөлөө зүсэх гэх мэт үйлдвэрийн осол гарах		x		x		x
Үйлдвэрийн барилга байгууламжийн гадна болон дотор цахилгааны утас гэмтэх, галын аюултай газарт ил гал гаргах зэргээр галын аюулгүй байдлыг хангаагүйгээс гал түймрийн аюул осол гарах		x		x		x
Үйлдвэрийн үйл ажиллагааны үед агаарт их хэмжээний тоосжилт болон бусад бохирдуулагч бодисууд тархаж орчны агаарын чанарт сөрөг нөлөөлөл үзүүлэх	x			x		x
Үйлдвэрийн технологиос үүсэж буй агаарын бохирдол нь ажилчид болон тухайн орчимд		x		x		x

ажиллаж амьдарч буй иргэдийн амьсгалын замын эрхтэн системийг гэмтээх							
Машин механизмын түлш, тос тосолгооны материал асгарч хөрс, газрын гүний усыг хүнд металлаар бохирдуулах		х		х		х	
Дүн	11	13	-	24	-	18	6

Тайлбар: х-болзошгүй нөлөөлөл, бэглэгдөөгүй нь тухайн төсөлд хамаарахгүй

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг магадлан жагсаах аргаар тодорхойлсон үр дүнгээс үзэхэд нөлөөллийн хэлбэрийн хувьд нийт нөлөөллийн 45.8% нь шууд, 54.2% нь шууд бус нөлөөлөлд хамрагдаж байна. Газрын доорх усны нөөц, хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдол, эрчим хүчний нөөц, газрын гадаргын нөөц баялаг, агаарын чанар зэрэгт шууд сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Харин шууд бус нөлөөлөлд ургамлын бүтэц, хөрсний үржил шимд нөлөөлөх, газрын доорх усны чанарын өөрчлөлт, хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх, хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх зэрэг нөлөөллүүд хамаарч байна.

Үйлдвэрийн үйл ажиллагаа улирлын чанартай боловч урт хугацаанд үргэлжлэх тул сөрөг нөлөөллийн үргэлжлэх хугацааг 100% урт хугацаанд хамруулан үзэв. Харин нөлөөллийн эрчмийг тодорхойлоход нийт нөлөөллийн 75 хувь нь дунд зэргийн, 25 хувь нь бага сөрөг нөлөөлөлд хамрагдаж байна.

Үйлдвэрээс байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь үндсэн түүхий эд материалууд болох элс, хайрга, цементийг үйлдвэрлэлд бэлтгэх, ачиж буулгах, зөөвөрлөх үед агаарт бий болох тоосжилт юм. Түүнчлэн газрын доорх усны нөөц, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, газрын доорх усны чанарт багаас дунд зэргийн эрчимтэй сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Тухайлбал машин механизм, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хүний үйл ажиллагаагаар хөрсөн бүрхэвч элэгдэж эвдрэх, хатуу шингэн хаягдлаар бохирдох, хөрсний өнгөн хэсэг талхлагдан доройтох, байгалийн ургамлан нөмрөг устгах, ургамлын ургалт саарч доройтох, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал алдагдсанаас шатахуун, тос тосолгооны материал асгарч хөрс болон газрын доорх усны чанарт сөргөөр нөлөөлөх, агаарт хийн төлөвт бохирдуулагч ялгарах, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалттай холбоотойгоор дуу чимээ ихээр үүсэж физик бохирдол бий болгох зэрэг сөрөг нөлөөлөл бий болж болзошгүй.

#### ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Ноц Бетон Зуурмаг ХХК” нь усыг хяналтгүй зарцуулах, бензин, дизель түлшээр ажилладаг тээврийн хэрэгслүүдийн дуу шаталт хөдөлгүүрээс хийн төлөвт бохирдуулагч ялгарч агаарын чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй зэрэг ажлуудыг төлөвлөсөн байна.




Зураг 3.1 Үйлдвэрийн хашаан доторх шороон замыг дагтаршуулсан байдал



Зураг 3.2 Машин механизмуудыг техникийн үзлэг оношилгоонд хамруулсан байдал






Зураг 3.3 Ус ашиглах гэрээ

**ДӨРӨВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТ**

“Ноц Бетон Зуурмаг” ХХК-ийн зуурмагийн үйлдвэрийн 2022 оны БОМТ-нд ногоон байгууламжийн төлөвлөгөөний хүрээнд үйлдвэрийн талбайн 10 хувиас багагүй талбайд ногоон байгууламж байгуулах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна. “Ноц бетон зуурмаг” ХХК нь үйлдвэрийн хашаан дотор нийт 10 ш мод тарьсан.



Зураг 4.1 Намар мод тарьсан байдал



Зураг 4.2 Хавар мод тарьсан байдал

#### ТАВ. ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

"Ноц Бетон Зуурмаг" ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны БОМТ-нд осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд болзошгүй осол аваарын үед анхан шатны тусламж үзүүлэх сургалтыг нийт ажилчдын дунд зохион байгуулах, үйлдвэрийн техник тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслүүдийн бүрэн байдал хангагдсан эсэхэд хяналт тавьж, шаардлагатай үед засвар үйлчилгээг хийж, аюулгүй ажиллагааг хангах, анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг байнга бэлэн байлгах, осол аваар гарч болзошгүй хэсгүүдэд анхааруулах зэрэг ажлуудын төлөвлөсөн байна.



Зураг 5.1 Осол аваар гарч болзошгүй хэсгүүдэд байршуулах



Зураг 5.2 Анхан шатны тусламжийн эм, тариа, багаж хэрэгслийг байнга бэлэн байлгах



Зураг 5.3 Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг хангаж, галын хорыг цэнэглэх



*Зураг 5.4 Ажлын дахь ХАБЭА болон болзошгүй осол аваарын үед анхан шатны тусламж үзүүлэх сургалтыг нийт ажилчдын дунд зохион байгуулсан байдал*

### **ЗУРГАА. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Ноц Бетон Зуурмаг ХХК-ийн Бетон зуурмагийн үйлдвэрийн 2022 оны БОМТ-нд хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгаж хаях, гэрээт байгууллагаар тогтмол тээвэрлүүлэх зэрэг ажлуудыг тусгасан бөгөөд хүнд даацын машин механизмын засвар үйлчилгээг зориулалтын талбайд гүйцэтгүүлэх, бетоны нэмэлт бодисын сав баглаа боодлыг тусгайлан бэлдсэн талбай дээр аюултай хог хаягдлын савыг бэлтгэж хаягжуулан, нэг удаагийн хэрэглээнээс татгалзах буюу нэг удаагийн аяга таваг бусад зүйлсийг огт хэрэглэхгүй байх, ахуйн хэрэглээний материалыг аль болох олон удаа ашиглах байдлаар үүсэж болох хаягдлыг бууруулах төлөвлөсөн байна.

#### **6.3 Хог хаягдлыг эрх бүхий байгууллагаар тээвэрлүүлдэг байдал:**

Үйлдвэрийн талбайд хог хаягдлыг тусгай талбайд ахуйн хог хаягдал, дахин боловсруулах хаягдал, хортой хаягдал гэсэн 3 саванд цуглуулах хогийн түр цэг байгуулж савнуудыг өнгөөр ялгаж ангилан ялгах зааварчилгаа, тэмдэг тэмдэглэгээ хийсэн.

Хан-Уул дүүргийн тохижилт үйлчилгээний газартай тухайн үед нь холбогдон тогтмол тээвэрлүүлж үйлчилгээний хураамжийг сар бүр төлдөг. Мөн хог хаягдлыг хогны цэгийн орчимд тогтмол ариутгал, цэвэрлэгээ хийдэг.






*Зураг 6.1 Үйлдвэрийн орчинд хогын савыг 3-н төрлөөр ялгаж ангилан байршуулсан байдал*

**6.4 Шингэн хаягдлыг бохирын цооногийн дүүрэлтийг 80 хувиас хэтрүүлэхгүй соруулан зайлуулдаг байдал:**

Шингэн хаягдлаа "Суман Хас" ХХК-тай хамтран гэрээ байгуулж одоог хүртэл тогтмол соруулдаг.

БАТЛАВ *Суман нас ХХК*  
Дарга  
*Х.Г. Агва*

БАТЛАВ "НОЦ БЕТОН ЗУУРМАГ" ХХК-ийн  
Захирагч *Мишугаа* Ч.Ариунталаа



**ҮЙЛЧИГЭЭ ҮЗҮҮГЭХ ГЭРЭЭ**

2022 оны 06-р сарын 25 өдөр № Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талдас "НОЦ БЕТОН ЗУУРМАГ" ХХК-ашигчид Захиалагч тал гэмтүүнийг тооловч

Нөгөө "Суман нас" ХХК /ашигчид Гүйцэтгэгч тал гэмтүүнийг тооловч менежер Г.Ганбуяад нар нь дээрхи нөхцөлөөр харилцан тохиролцож зөвшөөрсөнөөр байгуулав.

**Нэг. Нийтлэг заалт**

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь Гүйцэтгэгч тал нь Захиалагч талын өмчлөлийн *БЭХХТМ* бохир усыг өөрийн ажиглах хүү, техник тоног тохөөрөмжөө ашиглан тээвэрлэх, захиалагч тал нь тухайн ажилд нь тохирсон хэлс төлөх болон талуудын эрх үүргийг харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү гэрээний хугацаа 2022 оны 06 сарын 25-ны өдрөөс 2023 оны 06 сарын 25-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.3 Талууд гэрээний хугацаа дуусгавар болоход гэрээг цуцлах талаар санал гараагүй тохиолдолд гэрээг нөхцөл нөхцөл хугацаатайгаар дахин сунгагдсанд тооцно.

**Хоёр. Төлбөр тооцоо, гүүнийг төлөх үндэслэл**

- 2.1 Хоёр тал харилцан тохиролцооноор үйлчилгээний ажлын нэг удаагийн тээвэрлэлтийн үнэ нь дөр дүрдэнээр байх бөгөөд уг үндс НoAT орсон /орлоггүй/ болно.  
2.1.1 10 тн машин 1 рейс нь *20,000* төгрөг байна.
